



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.22 № 07/33 УАТ-САГ(2013)/19-СТА-ТС

**БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ҮҮРГИЙН САНГИЙН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
Ц.ЖАДАМБАА ТАНАА**

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тус сангийн харилцах данснаас 2012 онд шатахууны талон авахад 5,520,000, сургалтад 748,400, томилолтод 3,581,420, нийт 9,849,820 төгрөгийг шилжүүлэхдээ авлага болон материалын дансаар дамжуулаагүй, зарцуулалтын нотлох баримт дутуу байхад шууд зардлын дансанд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн сангийн харилцах данснаас 2012 оны 12 дугаар сарын 26-ны 109 дүгээр шилжүүлгээр "Юнител" ХХК-д сангийн нэр бүхий 6 ажилтны гар утасны ярианы төлбөр нийт 660,000 төгрөгийг шилжүүлсэн нь Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам"-ын 6.1." Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглаж, зарцуулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн дээрх зардлуудын нотлох баримтыг холбогдох ажилтнуудаас гаргуулан авч зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус сангийн Ажлын албаны дарга Б.Буян Өлзий, нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**


**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**

**Л.ОДГЭРЭЛ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

**БНҮҮС-гийн нягтлан бодогч**

**Б.Бямбасүрэн**



070096